**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сан 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДАА-2025/7/НА-СТА-ОНТС**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.opendatalab.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр<br>Утас: 70373089, 99023682<br>Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Батсүрэн<br>Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn<br>Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК<br>Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui. audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**Асуудлыг онцолсон хэсэг** ........ 4

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог Хөгжүүлэх сангийн 2024 оны нийт 515,000.0 мянган төгрөг батлагдсанаас 0.9 хувь буюу 4,820,6 мянган төгрөгийн зардал гарсан. Гарсан зардлын 13.4 хувь буюу 648.0 мянган төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, 86.5 хувь буюу 4,172.6 мянган төгрөгийг Бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан. 2024 онд 6 удаа төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч нэг ч хоршоо шалгараагүй учир зээл олгогдоогүй болно........ 4

**Аудитын гол асуудал** ........ 4

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 6

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 11

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 13

**4.1 Ерөнхий зүйл** ........ 13

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 14

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 14

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. ........ 14

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 14

**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 14

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна. ........ 15

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 15

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 15

**5.1 Төлбөрийн акт** ........ 15

Хоршоо хөгжүүлэх сан нь 2024 онд 1,599.9 мянган төгрөгийн хурдан скайнерийг зориулалт бусаар худалдан авсан ба ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгох шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"ийн 2.7 дахь хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлээгүй нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэглийг хангахгүй байна. ........ 15

**5.2 Албан шаардлага** ........ 15

**5.3 Зөвлөмж** ........ 15

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЗГ | Засгийн газар |
| ИТХ | иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| АЗДТГ | Аймгийн засаг даргын тамгын газар |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 111

танай ______________-ны №______________ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Т.ТУЛГАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог Хөгжүүлэх сангийн 2024 оны нийт 515,000.0 мянган төгрөг батлагдсанаас 0.9 хувь буюу 4,820,6 мянган төгрөгийн зардал гарсан. Гарсан зардлын 13.4 хувь буюу 648.0 мянган төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, 86.5 хувь буюу 4,172.6 мянган төгрөгийг Бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан. 2024 онд 6 удаа төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч нэг ч хоршоо шалгараагүй учир зээл олгогдоогүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 10 сарын 04-ний өдрийн А/521 дүгээр тушаалаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл

4525020131

олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын заалтуудад өөрчлөлт орж иргэн, хуулийн этгээд, Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэснийг хасаж зөвхөн хоршоонд зээл олгохоор болсон. Энэ онд зээл олгогдоогүй ба 252,342.7 мянган төгрөг эргэн төлөлт үүнээс 225,764.6 мянган төгрөгийн үндсэн зээл, 19,601.4 мянган төгрөгийн хүү, 6,976.7 мянган төгрөгийн алдангийн орлого төвлөрсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан сумын Засаг даргын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээ баталсан. Нийт 515000,0 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Үүнээс үндсэн үйл ажиллагааны зардалд 0.9 хувь буюу 4,820,6 мянган төгрөгийн зардал гарсан. 2024 онд 6 удаа төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч нэг ч хоршоо шалгараагүй учир зээл олгогдоогүй гүйцэтгэл 0,94 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

***ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР*** ***Ш.МӨНХБАЯР***

9022899
4517143626

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

____________________№____________________

танай ______________-ны №________________ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Т.ТУЛГАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог Хөгжүүлэх сангийн 2024 оны нийт 515,000.0 мянган төгрөг батлагдсанаас 0.9 хувь буюу 4,820,6 мянган төгрөгийн зардал гарсан. Гарсан зардлын 13.4 хувь буюу 648.0 мянган төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, 86.5 хувь буюу 4,172.6 мянган төгрөгийг Бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан. 2024 онд 6 удаа төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч нэг ч хоршоо шалгараагүй учир зээл олгогдоогүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020142

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 10 сарын 04-ний өдрийн А/521 дүгээр тушаалаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын заалтуудад өөрчлөлт орж иргэн, хуулийн этгээд, Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэснийг хасаж зөвхөн хоршоонд зээл олгохоор болсон. Энэ онд зээл олгогдоогүй ба 252,342.7 мянган төгрөг эргэн төлөлт үүнээс 225,764.6 мянган төгрөгийн үндсэн зээл, 19,601.4 мянган төгрөгийн хүү, 6,976.7 мянган төгрөгийн алдангийн орлого төвлөрсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан сумын Засаг даргын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээ баталсан. Нийт 515000,0 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Үүнээс үндсэн үйл ажиллагааны зардалд 0.9 хувь буюу 4,820,6 мянган төгрөгийн зардал гарсан. 2024 онд 6 удаа төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч нэг ч хоршоо шалгараагүй учир зээл олгогдоогүй гүйцэтгэл 0,94 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

***ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР*** ***Ш.МӨНХБАЯР***

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,111,405,711.98** | **1,107,333,264.88** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 190,748,794.98 | 438,270,929.20 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 190,748,794.98 | 438,270,929.20 |
| **3121** | **Төгрөг** | 190,748,794.98 | 438,270,929.20 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 190,748,794.98 | 438,270,929.20 |
| **33** | **АВЛАГА** | 920,656,917.00 | 669,062,335.68 |
| **335** | **Бусад авлага** | 920,656,917.00 | 669,062,335.68 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 920,656,917.00 | 669,062,335.68 |
| **39** | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | | **1,111,041.63** |
| 39200 | Биет хөрөнгө | | 1,111,041.63 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | | 1,599,900.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (488,858.37) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,111,405,711.98** | **1,108,444,306.51** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,111,405,711.98** | **1,108,444,306.51** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,111,405,711.98 | 1,108,444,306.51 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,111,405,711.98 | 1,108,444,306.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,111,405,711.98 | 1,111,405,711.98 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (2,961,405.47) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,111,405,711.98** | **1,108,444,306.51** |

ХТО5430 9022899

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **76,437,763.85** | **748,166.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **76,437,763.85** | **748,166.90** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 76,437,763.85 | **748,166.90** |
| 120002 | Хүүгийн орлого | 71,561,943.85 | |
| 120003 | Торгуулийн орлого | 4,875,820.00 | |
| 120004 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 748,166.90 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **8,527,950.00** | **3,709,572.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,527,950.00** | **3,709,572.37** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 8,527,950.00 | **3,709,572.37** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,122,500.00 | 648,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,122,500.00 | 648,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,405,450.00 | **3,061,572.37** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,405,450.00 | 2,572,714.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 488,858.37 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **67,909,813.85** | **(2,961,405.47)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **67,909,813.85** | **(2,961,405.47)** |

ХТС5430®9022880

**СТ-3А**

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **364,635,138.85** | **252,342,748.22** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **364,635,138.85** | **252,342,748.22** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 364,635,138.85 | **252,342,748.22** |
| 120002 | Хүүгийн орлого | 21,379,542.25 | 0 |
| 120003 | Торгуулийн орлого | 4,532,986.85 | 0 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 338,722,609.75 | 252,342,748.22 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 338,722,609.75 | 252,342,748.22 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **8,527,950.00** | **8,527,950.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,527,950.00** | **8,527,950.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **8,527,950.00** | **8,527,950.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,977,500.00 | 648,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,977,500.00 | 648,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,550,450.00 | **2,572,714.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,550,450.00 | 2,572,714.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **356,107,188.85** | **249,122,034.22** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | | |
| 223001 | Бусад хөрөнгө | | 1,599,900.00 |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | | **(1,599,900.00)** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 395,300,000.00 | 0 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 395,300,000.00 | 0 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(395,300,000.00)** | **0** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (39,192,811.15) | **247,522,134.22** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 229,941,606.13 | 190,748,794.98 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 190,748,794.98 | 438,270,929.20 |

CT-4A

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ Төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2023 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,043,495,898.13** | **1,043,495,898.13** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **1,043,495,898.13** | **1,043,495,898.13** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | **67,909,813.85** | **67,909,813.85** |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,111,405,711.98** | **1,111,405,711.98** |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,111,405,711.98** | **1,111,405,711.98** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **1,111,405,711.98** | **1,111,405,711.98** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| **D08** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **(2,961,405.47)** | **(2,961,405.47)** |

XTO5430 @ 9022699

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 515,000,000.00 | 4,820,614.00 | (510,179,386.00) | 0,94 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 15,000,000.00 | 4,820,614.00 | (10,179,386.00) | 32,1 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 15,000,000.00 | 4,820,614.00 | (10,179,386.00) | 32,1 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | - | | |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 648,000.00 | 648,000.00 | - | 100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 648,000.00 | 648,000.00 | - | 100 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,352,000.00 | 4,172,614.00 | (10,179,386.00) | 29,1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,352,000.00 | 4,172,614.00 | (10,179,386.00) | 29,1 |
| 23 | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 500,000,000.00 | 0 | (500,000,000.00) | 0 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 500,000,000.00 | 0 | (500,000,000.00) | 0 |
| 1200 | Татварын бус орлого | 500,000,000 | 252,342,748.22 | 247,657,251.78 | 50,4 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 500,000,000 | 252,342,748.22 | 247,657,251.78 | 50,4 |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **190,748,795.00** | 190,748,795.00 | 100.00 |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **438,270,929.20** | **438,270,929.20** | 100.00 |
| 1 | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | - | |
| 2 | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - | 100.00 |
| 3 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сан нь Хоршоодын үйл ажиллагааг чадавхижуулах-жишиг хоршоог бий болгох" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2024 оны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Хоол, хүнс үйлдвэрлэл:

- Хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Бүтэн боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Хүнсний ногоо, жимс жимсгэний боловсруулалт
- Сав баглаа боодол үйлдвэрлэл

2. Ферм, Мал аж ахуй
   - Фермерийн барилга байгууламж, тоног төхөөрөмж
   - Малын үүлдэр угсааг сайжруулах
   - Малын түүхий эдийг дахин боловсруулах үйлдвэрлэл
   - Мал эмнэлгийн үйлчилгээ

3. Бусад гэсэн чиглэлээр хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгох тэргүүлэх чиглэлийг баталсан.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

- Төвсийн тухай хууль
- Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгол, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *орсон* байна. Үүнд:

- Монгол Улсын Сангийн Сайдын 2023 оны 11 сар 211 дүгээр тушаал: Ангилал шинэчлэн батлах тухай
- Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023.10.04-ны 521 дүгээр тушаал: Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгол, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журамд өөрчлөлт орсон / Иргэн, Аж ахуйн нэгж, байгууллага хасагдсан/

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сан нь тусдаа бие даасан байгууллага биш тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан албан хаагч байхгүй бөгөөд Төсвиййн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх санд хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудит/аудторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сан 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

*Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан хэрэглэдэг Дархан сумын Засаг даргын тамгын газрын захиалгаар "Нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх сан" ТББ -ийн 2020 онд боловсруулсан НББ-ын бодлогын баримт бичиг ашигладаг ба Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сан нь тусдаа бие даасан байгууллага биш тул нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг боловсруулаагүй.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,961.5 мянган төгрөгөөр буюу 0,99 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 190,748.80 | 438,270.9 | 247,522.1 |
| Авлага | 920,656.90 | 669,062.3 | (251,594.6) |
| Бараа материал | - | - | - |
| Үндсэн хөрөнгө | - | 1,111.0 | 1,111.0 |
| Үндсэн хөрөнгө элэгдэл | | | |
| **Нийт хөрөнгө** | **1,111,405.70** | **1,108,444.20** | **(2,961,5)** |
| Өр төлбөр | | | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,111,405.70 | 1,108,444.20 | (2,961.5) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,111,405.70** | **1,108,444.20** | **(2,961.5)** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 438,270.9 мянган төгрөг болж өмнөх оноос 247,522.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тус онд зээл олгоогүй ба авлага барагдуулах ажиллагаа явуулсан нь дансны үлдэгдэл өсөлттэй гарахад нөлөөлсөн.

Авлагын дансны үлдэгдэл 669,062.3 мянган төгрөг болж 251,594.6 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт 34 зээлдэгчээс муу 11 зээлдэгчийн 111.031.1 мянган төгрөг, эргэлзээтэй 2 зээлдэгч 61,006.0 мянган төгрөг, хэвийн 21 зээлдэгчийн 497,025.2 мянган төгрөгийн авлагатай байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,108,444.2 мянган төгрөг болж 2,961.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үйл ажиллагааны орлогоос 515,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 515,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 515,000.0 мян төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 515,000.0 мян төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлого 252,342.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,820.6 мянган төгрөг буюу 0,94 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 10,179.4 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлийн зардлыг 500,000.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70106/80101 | 15,000.0 | 4,820.6 | (10,179.4) | 32.1 |
| 2 | 70106/83111 | 500,000.0 | 0.0 | (500,000.0) | 0 |
| | Дүн | 515,000.0 | 4,820.6 | (510,179.4) | 0.94 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/115 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүнгийн 1,111.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,599.9 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 1,599.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.1 Төлбөрийн акт

Хоршоо хөгжүүлэх сан нь 2024 онд 1,599.9 мянган төгрөгийн хурдан скайнерийг зориулалт бусаар худалдан авсан ба ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгох шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"ийн 2.7 дахь хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлээгүй нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгллийг хангахгүй байна.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Бичиг хэрэг, шуудангийн зардалтай холбоотой асуудал

***1.1. <u>Илрүүлэлт</u>:***

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалын дагуу “docx.gov.mn” албан бичиг солилцооны дундын системийг ашиглаагүй байна

**1.2 *<u>Өгсөн</u>* <u>зөвлөмж</u>:**

Бичиг хэрэг, шуудангийн зардлыг бууруулах зорилгоор албан бичиг солилцооны дундын системийг ашиглах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Зориулалт бусаар худалдан авсан | 1 | 1,599.9 | 1 | 1,599.9 | | | | | | | | |
| Дүн | 1 | 1,599.9 | | 1,599.9 | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж |

[2] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| "docx.gov.mn" албан бичиг солилцооны дундын системийг ашиглаагүй | 1 | - | | | | | 1 | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |